

**Улсын төсвөөс хайгуулын ажилд гарсан  
зардлыг нөхөн төлөх тухай  
ГЭРЭЭ**

2016 оны 06 дугаар  
сарын 28-ны өдөр

дугаар ХА3-2016/29/27

Улаанбаатар  
хот

**Ерөнхий зүйл**

Нэг талаас Ашигт малтмалын газар, нөгөө талаас ашигт малтмалын ордын MV-011668 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшигч Улсын бүртгэлийн албанад бүртгэлтэй 9019004024 тоот гэрчилгээ, 5003539 тоот регистрийн дугаартай "Нордвинд" ХХК /цаашид аж ахуйн нэгж/ нь Ашигт малтмалын тухай хууль, Засгийн газрын 2007 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн дугаар 81 тоот тогтоолоор батлагдсан журмыг үндэслэн улсын төсвийн хөрөнгөөр хийсэн Хэнтий аймгийн Галшар сумын нутагт орших Бичигт нэртэй хайлуур жоншны орд дээр хийгдсэн геологийн зураглал, судалгааны ажлын зардлуудыг улсын төсөвт эргүүлэн нөхөн төлөх нөхцөл, үе шат, төлбөрийн хэмжээ, хүлээх хариуцлагыг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

**Нэгдүгээр зүйл. Ерөнхий эрэл, урьдчилсан хайгуул, нарийвчилсан хайгуул,  
гидрогоеологийн хайгуул, зураглалын ажлын зардлын нийт хэмжээ**

Хэнтий аймгийн Галшар сумын нутагт орших Галшар нэртэй хайлуур жоншны орд дээр байрлах MV-011668 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд 1956-57, 1982, 2000 онуудад улсын төсвөөс нийтдээ 863 896.58 төгрөгийн зардал гарсан бөгөөд ноогдох хэмжээг үндэслэн Засгийн газрын 2007 оны 81 дүгээр тогтоолоор баталсан журамд заасан аргачлалын дагуу тооцоход 2016 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн Монгол банкны албан ёсны ханшиг /1\$= 1998.33/ үндэслэн тооцоход 643 063 803 төгрөг буюу 321 800.6 ам.доллар болж байгааг хоёр тал хүлээн зөвшөөрөв.

**Хоёрдугаар зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх эрх, үүрэг**

1. Энэхүү гэрээний нэгдүгээр зүйлд заасан зардлыг 5 жилийн хугацаанд төлөх бөгөөд төлбөр хийх өдрийн төгрөг, америк долларын ханшаар тооцож төгрөгөөр эсвэл шууд америк доллараар төлнө.

2016 онд 5 000.0 ам.долл. / таван мянган ам.доллар / ам.доллар  
(тоогоор) (үсгээр)

2017 онд 48 067.36 ам.долл. / дөчин найман мянга жаран долоон ам.доллар гучин  
зургаан цент / ам.доллар  
(тоогоор) (үсгээр)

2018 онд 64 407.82 ам.долл. / жаран дөрвөн мянга дөрвөн зуун долоон ам.доллар  
наян хоёр цент / ам.доллар  
(тоогоор) (үсгээр)

2019 онд 80 509.77 ам.долл. / наян мянга таван зуун ёсөн ам.доллар далан долоон  
цент / ам.доллар  
(тоогоор) (үсгээр)

2020 онд 123 815.65 ам.долл. / зуун хорин гурван мянга найман зуун арван таван  
ам.доллар жаран таван цент / ам.доллар  
(тоогоор) (үсгээр)

№ХА3-2016/20/27/Гэрээ

ЭХ СУРВАЛЖ: [WWW.ILTODGEREE.MN](http://WWW.ILTODGEREE.MN)

2. Энэхүү гэрээний хоёрдугаар зүйлийн 2.1-т дурьдсан онуудад хийхээр хуваарилсан төлбөрийг тухайн онд хавсралт 1-д заасан байдлаар Төрийн сан банкны төгрөгийн 900000712 Ашигт малтмалын газрын дансанд хийнэ.

3. Хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөр хийсний дараа уг төлбөр Ашигт малтмалын газрын дансанд орсон эсэхийг шалгаж болно.

4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү гэрээний 2 дугаар зүйлийн 2, 3-аар тохиролцсон үүргийн дагуу тухайн улирлын төлбөрөө улиралдаа багтаан хийгээгүй бол Ашигт малтмалын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 7 дахь заалтын дагуу хугацаа хэтэрсэн хоног тутам тухайн улиралд төлбөл зохих төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх алданги төлнө.

### **Гуравдугаар зүйл. Ашигт малтмалын газрын хүлээх үүрэг, эрх**

1. Энэхүү гэрээний нэгд заасан нөхөн төлбөрийн хэмжээг нөхөн төлбөр хийхээр тохиролцсон хугацаанд өөрийн санаачилгаараа өөрчлөхгүй.

2. Нөхөн төлбөр хийсэн хугацааг банкинд гүйлгээ хийсэн өдрөөр тооцно.

3. Нөхөн төлбөр хийсэн баримт бичигтэй танилцан төлбөрийн хэмжээ үнэн зөв эсэхийг магадлахдаа төлбөр хийсэн өдрийн америк доллар ба төгрөгийн Монгол банкаас зарласан албан ёсны ханшийг баримтална:

### **Дөрөв. Бусад зүйл**

1. Ашигт малтмалын газар болон аж ахуйн нэгжийн төлөөлөгчид энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар гэрээ хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү гэрээний хоёрдугаар зүйлийн 2 дахь заалтын биелэлтийг Ашигт малтмалын газар болон аж ахуйн нэгжийн төлөөлөгчид хамтран дүгнэж акт үйлдэнэ.


3. Гэрээг гурав хувь үйлдсэн бөгөөд нэг хувийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, нэг хувийг Ашигт малтмалын газар, нэг хувийг ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч тус тус хадгална. Гэрээний хувиуд нэгэн адил хүчин төгөлдөр байна. Гэрээ нь хавсралттайгаа нийт гурван хуудаснаас бүрдэнэ.

4. Аж ахуйн нэгж нь энэхүү гэрээний заалтуудыг биелүүлээгүй тохиолдолд Ашигт малтмалын газар нь шүүхэд хандаж болох бөгөөд шүүх ажиллагаатай холбогдон гарах зардлыг аж ахуйн нэгж хариуцан төлнө.

### **Гэрээ байгуулсан:**


**АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗРЫГ  
ТӨЛӨӨЛЖ:**

Уул уурхайн хэлтсийн  
дарга ..... С.Баттулга



**ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ  
ЭЗЭМШИГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

"Нордвинд" ХХК-ийн  
захирал ..... Зинг Чум



№ХА3-2016/29/28 гэрээ

ЭХ СУРВАЛЖ: [WWW.ILTODGEREE.MN](http://WWW.ILTODGEREE.MN)

Ашигт малтмалын газар & "Нордвинд" ХХК-ийн Бичигт нэртэй хайлуур жоншны ордын Хайгуулын ажлын зардлыг нөхөн төлөх гэрээ

Хавсралт №1

2016 онд

Улирлууд	Төлбөл зохих US\$	Төлбөр хийсэн өдрийн төгрөг ба америк долларын ханш	Төлсөн нь	Төлбөр хийсэн он сар өдөр бусад тэмдэглэл
1				
2				
3	+		12.434.900.	
4	5 000.0	2486.988	10000,000	2016-12-27. Бадсанжил

2017 онд

Улирлууд	Төлбөл зохих US\$	Төлбөр хийсэн өдрийн төгрөг ба америк долларын ханш	Төлсөн нь	Төлбөр хийсэн он сар өдөр бусад тэмдэглэл
1				
2				
3	+			
4	48 067.36			

2018 онд

Улирлууд	Төлбөл зохих US\$	Төлбөр хийсэн өдрийн төгрөг ба америк долларын ханш	Төлсөн нь	Төлбөр хийсэн он сар өдөр бусад тэмдэглэл
1				
2				
3	+			
4	64 407.82			

2019 онд

Улирлууд	Төлбөл зохих US\$	Төлбөр хийсэн өдрийн төгрөг ба америк долларын ханш	Төлсөн нь	Төлбөр хийсэн он сар өдөр бусад тэмдэглэл
1				
2				
3	+			
4	80 509.77			

2020 онд

Улирлууд	Төлбөл зохих US\$	Төлбөр хийсэн өдрийн төгрөг ба америк долларын ханш	Төлсөн нь	Төлбөр хийсэн он сар өдөр бусад тэмдэглэл
1				
2				
3	+			
4	123 815.65			

*ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN*

№ХА3- 2016/20/20 гэрээ